

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2019.11.25 - 11.29

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: Энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. Энэхүү өсөлт нь АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны хэлэлцээрийн эхний шаттай холбоотой байлаа.

S&P 500 индексийн сагсанд багтах өргөн хэрэглээний бус бараа бүтээгдэхүүний худалдаа эрхэлдэг компаниудын хувьцаа хамгийн их өсөлттэй байлаа. Энэхүү өсөлт нь баярын өдрүүдэд цахим худалдан авалт өссөнөөс үүдэн Amazon.com компанийн хувьцаа өсөлт үзүүлсэнтэй холбоотой.

Энэ долоо хоног мөн томоохон компаниуд худалдан авах санал ихээхэн гаргасан долоо хоног болсон ба Charles Schwab өрсөлдөгч брокерийн компани болох TD Ameritrade компанийг худалдан авах гэж буйг мэдэгдсэн бол Францын тансаг зэрэглэлийн бараа үйлдвэрлэгч VMH Moët Hennessy Louis Vuitton компани Tiffany & Co компанийг худалдан авах санал гаргасан гэдгээ мэдэгджээ.

Европ: Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны хэлэлцээрт ахиц гарсантай холбоотой өсөлт үзүүллээ.

YouGov урьдчилсан санал асуулгаар Их Британийн Консерватив нам 12-р сарын 12-ны өдөр болох бүх нийтийн сонгуулиар 359 суудлын ялалт байгуулахаар байгаа ба энэ нь сүүлийн жилүүдэд болсон хамгийн том олонх болох юм. Их Британийн Ерөнхий Сайд ноён Борис Жонсон Зул сарын баяраас өмнө Brexit-ийн шинэ хэлэлцээрийг Парламентад танилцуулна хэмээн амлаад байгаа юм.

ХБНГУ-ын GfK агентлагаас хэрэглэгчдийн хандлага сайжирч байгааг мэдээллээ. Хэрэглэгчдийн хандлага сайжирсан нь өрхийг хэрэглээг өсгөн экспорт төвтэй ХБНГУ-ын эдийн засагт эерэгээр нөлөөлөх юм. ХБНГУ-ын эдийн засгийн идэвх сүүлийн үед АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны маргаан болон Brexit-тэй холбоотой саарах төлөвтэй байсан билээ.

Япон: Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй байсан ч Япон улсын 10-р сарын үйлдвэрлэлийн гарц хүлээлтээс илүү буурсантай холбоотойгоор энэхүү өсөлт хязгаарлагдав.

ОУВС-аас Япон улсын 2019 оны санхүүгийн жилийн ДНБ-ийн өсөлтийг дэлхийн эдийн засгийн бууралттай холбоотойгоор 0.9%-аас 0.8% болгон бууруулсан байна. ОУВС-аас Япон улсын эрх баригчдад худалдан авалтын хэмжээгээ ойрын хугацаанд бууруулахгүй байхыг зөвлөж байгаа юм.

БНХАУ: БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд АНУ-ын Ерөнхийлөгч ноён Доналд Трамп Хонг Конгийн эсэргүүцлийн жагсаалыг дэмжсэн хууль баталсантай холбоотой уналттай байлаа. Энэхүү хуулийг баталснаас үүдэн БНХАУ болон АНУ-ын хооронд яригдаж байсан худалдааны эхний шатны хэлэлцээрийг байгуулахад хүндрэлтэй болно хэмээн шинжээчид үзэж байна.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	18,774.08	1.09% ▲
Dow Jones	АНУ	28,051.41	0.63% ▲
S&P 500	АНУ	3,140.98	0.99% ▲
Nasdaq	АНУ	8,665.47	1.71% ▲
S&P/TSX	Канад	17,040.20	0.50% ▲
FTSE 100	Их Британи	7,346.53	0.27% ▲
S&P/ASX 200	Австрали	6,846.00	2.03% ▲
Nikkei 225	Япон	23,293.91	0.78% ▲
Hang Seng	Хонг Конг	26,346.49	-0.93% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	112.87
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	102.81
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	101.93
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	109.42
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	103.39
DBM' 2023	USD	7.250%	105.58
TDBM' 2020	USD	9.375%	102.49
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	97.53

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	1.700	0.00
Libor 3M	1.910	0.01 ▲
Libor 6M	1.900	-0.01 ▼
Libor 1YR	1.950	0.01 ▲
US 2YR Bond	1.624	0.00
US 3YR Bond	1.628	0.01 ▲
US 5YR Bond	1.651	0.02 ▲
US 10YR Bond	1.809	0.04 ▲

Валютын ханш /төг/

Валют	2019.11.2	Өөрчлөлт
USD	2,715.22	0.32% ▲
CNY	386.41	0.43% ▲
EUR	2,989.86	-0.17% ▼
RUB	42.36	-0.28% ▼
KRW	2.30	0.00%
JPY	24.80	-0.48% ▼
CAD	2,044.29	0.29% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,463.98	0.14% ▲
Мөнгө /spot/	USD/t oz.	16.92	-0.60% ▼
Зэс	USD/lb.	266.15	0.09% ▲
Нүүрс	USD/MT	72.00	-1.40% ▼
WTI газрын тос	USD/bbl.	55.17	-4.50% ▼
Brent газрын тос	USD/bbl.	62.43	-1.51% ▼

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. X	7.60%
Бодлогын хүү	2019. X	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. X	11.06%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. X	11.48%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. X	4.82%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. X	16.90%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. X	10.61%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg


МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 46 компанийн 12,753.3 сая төгрөгийн 3,220,857 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Хөх ган” /HGN/ компанийн хувьцаа 17.57%-аар буюу хамгийн ихээр өсөж 87.0 төгрөгт хүрч хаагдсан бол “Улсыг их дэлгүүр” /UID/ компанийн хувьцаа 18.44%-аар буурч 1,101.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

11-р сарын 29-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,530.5 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 18,774.08 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 1.09%-аар өссөн байна.



Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	12,753.3
Зах зээлийн үнэлгээ	2,530,514.0

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	18,774.08	1.09% ▲
MSE I индекс	8,448.15	-2.69% ▼
MSE II индекс	7,708.40	-0.24% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
МИК Холдинг	895,610	12,183,883,800
Могойн гол	13,346	120,114,000
Ард кредит ББСБ	1,242,275	97,221,568
Ард санхүүгийн нэгдэл	41,218	70,515,108
Сүү	319,439	61,620,980

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Хөх ган	87.00	17.57% ▲
Агротехимпекс	911.00	13.93% ▲
Материалимпекс	6,800.00	13.33% ▲
Адуун чулуун	1,440.00	12.06% ▲
Би ди сек	948.00	10.23% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Улсын их дэлгүүр	1,101.00	-18.44% ▼
Ремикон	26.52	-15.70% ▼
Сор	964.75	-15.00% ▼
Хэрлэн хивс	50.00	-13.79% ▼
Монинжбар	101.00	-11.44% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Ти Ди Би Капитал	24,405,004,518
Би Ди Сек	266,757,130
Гаули	249,318,217
Ард Секюритиз	198,320,214
Голомт Капитал	101,365,510

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	577.01	614,043
Таван толгой	6,500.00	342,324
МИК Холдинг	12,230.00	253,275
Говь	252.33	196,846
Инвескор ББСБ	2,148.00	154,072

ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
---	-----------------	--------------------	-----------------	------------	------------	---------	-----

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.18-нд олгов
2	LEND	ЛэндМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.03.28-нд олгов
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.06.14-нд олгов
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дюти фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.04.24-нд олгов
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.27-нд олгов
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.05.20-нд олгов
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.17-нд олгов
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.21-нд олгов
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.04.29-с
22	HNS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.05.15-с
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	2019.07.19-нд олгов
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.07.26-нд олгов
28	TEE	Тээвэр дархан ХК	22.3	81.7	365.5%	500.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
29	ERS	Монгол алт ХК	6.3	39.9	631.2%	150.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
30	TTL	Таван толгой ХК	52,858.1	44,923.4	85.0%	853.0	2019.04.26	2019.04.01	2019.06.11-нд олгов
31	EER	Ариг гал ХК	449.3	109.4	24.3%	32.5	2019.04.26	2019.03.27	2019.09.30-ны дотор
32	HRM	Гермес центр ХК	481.3	447.7	93.0%	5.7	2019.08.15	2019.09.02	2019.09.18-нд олгов
33	SUU	Сүү ХК	5,706.4	1,143.4	20.0%	3.3	2019.09.09	2019.04.05	2019.10.24-нд олгов

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Баялаг сүмбэр” ХК-ийн оноосон нэр “Глобал лайф технологи” ХК болж өөрчлөгдлөө

Монголын хөрөнгийн биржийн 3-р ангилалд бүртгэлтэй “Баялаг сүмбэр” ХК-ийн 2019 оны 7-р сарын 01-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар тус компанийн нэрийг өөрчилж, дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсантай холбогдуулан Монголын Хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 2019 оны 8-р сарын 20-ны өдрийн А/60 тоот тушаал болон Санхүүгийн Зохицуулах Хорооны даргын 2019 оны 11-р сарын 14-ний өдрийн тушаалаар “Баялаг сүмбэр” ХК-ийн оноосон нэрийг “Глобал лайф технологи” ХК болгон өөрчлөлт орууллаа.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Атар өргөө” ХК-ийн хувьцааг үүргээ хэрэгжүүлэх үндсэн дээр худалдан авах саналыг дахин хүргүүлж байна

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2 дахь заалтад заасан “Компанийн хувьцааны хяналтын багцыг дангаараа буюу холбогдох этгээдтэй хамтран худалдан авсан хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 57.1-д заасан үүргээ хэрэгжүүлэх үндсэн дээр компанийн хувьцааг худалдан авах санал гаргана” гэж заасныг удирдлага болгон “Таван Богд Инвест” ХХК нь МХБ-ийн үнэт цаасны 2-р ангилалд бүртгэлтэй “Атар Өргөө” ХК-ийн 97,423 ширхэг энгийн хувьцаа буюу нийт энгийн хувьцааны 55.95 хувийг худалдан авах саналыг СЗХ-ны “Хувьцаат компанийн хувьцааг худалдан авах санал гаргах, хувьцааг худалдан авах ажиллагааны журам”-ын 5.4 заасны дагуу 15 хоногийн дараа дахин хүргүүлж байна.

Санал гаргаж буй этгээд: “Таван Богд Инвест” ХХК /РД: 6470319, УБД: 9011811139/

Санал болгож буй үнэ: 60,200 төгрөг

Худалдан авах тоо ширхэг: 97,423 ширхэг

Хувьцааг худалдан авах саналын эхлэх хугацаа: 2019 оны 11-р сарын 13

Хувьцааг худалдан авах саналын дуусах хугацаа: 2019 оны 12-р сарын 16-ны өдрийн 13:00 цаг

Хувьцааны худалдан авах төлбөрийг гүйцэтгэх хугацаа: 2019 оны 12-р сарын 17- ны өдөр

Санал гаргагчийн эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг: 76,713 ширхэг хувьцаа буюу нийт хувьцааны 44.05%

Санал гаргагчийн харилцагч үнэт цаасны компани: “Би Ди Сек ҮЦК” ХК, 75551919-04

Санал хүлээн авах хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүрэг, 8-р хороо, Бага тойруу 16 б,

Мэйл хаяг: invest@tavanbogd.com,

Утас: 75112222.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“МИК Холдинг” ХК-ийн багцын арилжаа явагдлаа

2019 оны 11-р сарын 25-ны өдөр “МИК Холдинг” ХК-ийн /MSE:MIK/ 2 удаагийн багцын арилжаа явагдлаа. 2 удаагийн багцын арилжаагаар тус компанийн нийт 895,610 ширхэг хувьцааг 12.2 тэрбум төгрөгөөр арилжсан ба 14,940 төгрөгөөр 539,500 ширхэг хувьцаа, 11,580 төгрөгөөр 356,110 ширхэг хувьцаа тус тус арилжаалагдсан байна.

“МИК Холдинг” ХК-ийн /MSE:MIK/ хувьд 2019 он гарснаас хойш нийт 5 удаагийн багцын арилжаа хийгдсэн бөгөөд үүнээс өмнө 11-р сарын 22-ны өдөр 4.1 тэрбум төгрөгийн багц хувьцаа арилжигдаж байсан юм.

Эх сурвалж: Ти Ди Би Капитал ҮЦК

Хорооны 2019 оны XVI хуралдаан болов

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны XVI хуралдаан болж нийт 31 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Хуралдаанаар “Нийслэлийн өмчит Улаанбаатар” ХХК, “Эрдэнэс ассет менежмент” ХХК-д хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, “Хөвсгөл алтан дуулга” болон “Лэндмн ББСБ” ХК-иудын хаалттай хүрээнд гаргаж буй өрийн хэрэгслийг бүртгэв.

Мөн “Мандал даатгал” ХК-ийн хувьцаа хуваах асуудлыг шийдвэрлэж, “Очун капитал” хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэж, нэр бүхий 3 компанийн хувьцааг тусгаарлалтаас чөлөөлж, нэг компанийн үнэт цаасыг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлээс хаслаа.

Түүнчлэн зарим даатгалын компанийн давхар даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа, төлөөлөгчийн газар, даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэж, нэр бүхий компаниудын даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, салбарыг нь бүртгэлээс хасах асуудлыг шийдвэрлэв.

Мөн нэр бүхий үнэт цаасны компани, хадгаламж зээлийн хоршоо, ББСБ-уудын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг сунгах, зөвшөөрөл нэмж олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

“Мандал даатгал” ХК-ийн арилжааг түр зогсоолоо

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2019 оны 11-р сарын 25-ны өдрийн хуралдаанаар “Мандал даатгал” ХК-ийн хүсэлтийн дагуу тус компанийн хувьцааг 100 хуваах замаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэнтэй холбогдуулан Улсын байцаагчийн 2019 оны 11-р сарын 28-ны өдрийн 79 тоот албан шаардлагаар хувьцаа хуваахтай холбоотой үйл ажиллагаа “ҮЦТХТ” ХХК-д бүрэн хийгдэж дуусах хүртэлх хугацаанд тус үнэт цаасны арилжааг түр зогсоолоо.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Монгол Улсын ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний код “МонВал”-ыг боловсруулах ажлын хэсэг хуралдлаа

Монгол Улсын Засгийн газар болон Австрали Улсын Засгийн газрын хоорондын хоёр талт хамтын ажиллагааны буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжүүлж буй “Австрали, Монголын Эрдэс баялгийн салбар дахь хамтын ажиллагааны хөтөлбөр”-тэй хамтран Монгол Улсын ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний код “МонВал”-ыг боловсруулах чиг үүрэг бүхий холбогдох байгууллагууд болон Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын төлөөллийг хамарсан ажлын хэсэг байгуулагдаад байна.

Ажлын хэсгийн анхдугаар хуралдаан 2019 оны 11-р сарын 22-ны өдөр болж, ажлын хэсгийн гишүүд санал солилцон ажилласны зэрэгцээ кодыг боловсруулах чиглэлээр хийгдэж байсан ажлууд болон олон улсад ашигт малтмалын үнэлгээг хэрхэн хийдэг талаар хөтөлбөрийн уул уурхайн ахлах зөвлөх Н.Алгаа, хөтөлбөрийн зөвлөх, Олон улсын ашигт малтмалын үнэлгээний хорооны дарга Стивен Гемелл нар танилцууллаа.

Энэхүү кодыг нэвтрүүлснээр ашигт малтмалын хөрөнгийг арилжаалах явцад хуурамч үнэлгээ хийгдэхээс урьдчилан сэргийлэх, уул уурхайн салбарт олон нийтийн итгэх итгэл үнэмшлийг нэмэгдүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулах юм. Мөн уул уурхайн компаниуд хөрөнгийн зах зээл дээр гарахад тухайн ашигт малтмалын нөөцийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу тайлагнадаг болох зэрэг чухал ач холбогдолтой.

Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

“Эрдэнэс тавантолгой” ХК хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг ирэх сард цэгцэлж дуусна

“Эрдэнэс тавантолгой” ХК нь охин компани байгуулж, эхний ээлжинд Зүүн Цанхийн тусгай зөвшөөрлийг эзэмшигч охин компанийнхаа 30 хүртэлх хувийг Хонгконгийн бирж дээр гаргахаар ажиллаж байгаа билээ.

Тэгвэл иргэдийн эзэмшиж буй 1072 хувьцааны арилжааг хэзээ эхлүүлэх талаар хүлээлт ихтэй байсаар байна.

Засгийн газраас өнгөрөгч 7-р сард “Эрдэнэс тавантолгой” ХК-тай холбоотой нэг тогтоол гаргасан бөгөөд уг

тогтоолын хүрээнд иргэд, компаниудын эзэмшиж буй хувьцааны бүртгэлийг нягтлан шалгаж эцэслэхийг холбогдох байгууллагуудад үүрэг болгосон. Уг ажлыг ирэх 12-р сарын 7-нд багтаан дуусгаж Засгийн газарт танилцуулахыг мөн даалгажээ.

Энэхүү ажил хийгдсний дараа арилжааг хэзээ, хэрхэн эхлүүлэх талаар тодорхой шийдэл гаргах хүлээлттэй байгаа юм.

Эх сурвалж: MarketInfo.mn

УУХҮ-ийн сайд Д.Сумъяабазар “Mines And Money London 2019” олон улсын чуулга уулзалтад оролцлоо

Лондон хотноо 17 дахь жилдээ уламжлал болон зохион байгуулагдаж байгаа дэлхийн уул уурхайн салбарынханы “MINES AND MONEY LONDON 2019” олон улсын чуулга уулзалтад УУХҮ-ийн сайд Д.Сумъяабазар болон холбогдох албаныхан оролцлоо. Энэхүү чуулга уулзалт бол уул уурхайн салбарын ололт амжилтыг бататгахын зэрэгцээ төр, хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын хамтын ажиллагаа өргөжүүлэх боломжийг олгодог юм. Чуулга уулзалтад олон улсын 2000 гаруй оролцогчид чуулсан байна. УУХҮ-ийн сайд Д.Сумъяабазар энэ удаагийн чуулга уулзалтаар Монголын Засгийн газрын уул уурхайн салбарт баримталж байгаа бодлого, хөгжлийн цаашдын чиг хандлагыг танилцууллаа. Тэрбээр “Монгол Улсын Засгийн газраас хариуцлагатай, ил тод, байгаль орчинд ээлтэй-ногоон, оролцоог хангасан, тэгш хуваарилалт бүхий уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байна. Уул уурхайн салбар нь манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 24 хувь, аж үйлдвэрийн салбарын 72 хувь, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 70 хувь, нийт экспортын 89 хувийг бүрдүүлдэг эдийн засгийн чухал салбар юм. Монгол Улсад хууль, дүрэм, журмууд гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг ялгалгүйгээр тэгш үйлчилдэг. Татварын орчны хувьд олон улсад өрсөлдөх чадвартай. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн хүрээнд тогтворжуулах гэрчилгээ олгох, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах замаар татварын хувь хэмжээг тогтворжуулдаг. Цаашид бид салбарын хуулиудын давхардал хийдлийг арилгах тал дээр дахин ажиллаж байгаа” гэлээ.

Мөн дэлхийн хэмжээний нүүрсний орд болох Тавантолгой, Эрдэнэс Монгол ХХК, хувийн хэвшлийн төлөөлөл Эрдэнэ Ресурс Дэвэллопмент Корпораци танилцуулгаа хийж дэлхийн уул уурхайнхны анхаарлын төвд орууллаа.

Эх сурвалж: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.